



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл сунгах, олгох тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Жененрал роль” ХХК-ийн “Тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх” аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. “Доктор авто сүлжээ” ХХК-д Хан-Уул дүүрэг. Наадамчдын зам гудамж, 503 байршилд “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх” тусгай зөвшөөрлийг техникийн хяналтын үзлэгийн суурин, суудлын автомашины төрлөөр 3 жилийн хугацаагаар олгосугай.

3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Батболд/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/-т үүрэг болгосугай.

САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ



080378